



ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Компанийн зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалт, Эрчим хүчний сайдын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн а/875 дугаар удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- 1."Дулаан шарын гол" ТӨХК-ийн зохион байгуулалтын бүтцийг нэгдүгээр хавсралтаар, орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- 2.Зохион байгуулалтын бүтцийг 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг гүйцэтгэх захирал /П.Баярцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 21 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Ш.ГАНЗОРИГ



КОМПАНИЙ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН БҮДҮҮВЧ



КОМПАНИЙН ОРОН ТОО



№	Албан тушаал	Орон тоо
1	Гүйцэтгэх захирал	1
2	Ерөнхий инженер	1
<i>Дотоод аудиторын алба</i>		1
3	Дотоод аудитор	1
<i>Дотоод хяналтын алба</i>		2
4	ХАБЭА-н инженер	1
5	Үйлдвэрийн техник хяналтын инженер	1
<i>Захиргаа удирдлагын хэлтэс</i>		9
6	Хэлтсийн дарга	1
7	Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн	1
8	Архив, бичиг хэргийн ажилтан	1
9	Жолооч	1
10	Харуул	4
11	Үйлчлэгч	1
<i>Санхүү борлуулалтын хэлтэс</i>		9
12	Ерөнхий нягтлан бодогч буюу хэлтсийн дарга	1
13	Эдийн засагч	1
14	Тооцооны нягтлан бодогч	1
15	Худалдан авалт, хангамж хариуцсан мэргэжилтэн	1
16	Борлуулалтын мэргэжилтэн	1
17	Борлуулалтын байцаагч	3
18	Касс, нярав	1
<i>Техникийн хэлтэс</i>		13
19	Горим, тооцооны инженер буюу хэлтсийн дарга	1
20	Нарийн хэмжүүр, автоматикийн инженер	1
21	Цахилгааны техникч	1
22	Химич	1
23	Диспетчер	4
24	Цахилгаанчин	5
<i>Дулааны станцын хэсэг</i>		38
25	Ашиглалтын инженер буюу хэсгийн дарга	1
26	Механикч	1
27	Ээлжийн дарга	4
28	Зуухны машинч	6
29	Туслах машинч	4
30	Түлш дамжлагын оператор	8
31	Зуухны засварчин	7
32	Гагнуурчин	2
33	Ус бэлтгэлийн лаборант	4
34	Үнсний машины жолооч	1
<i>Ус, дулаан ариутгах татуургын хэсэг</i>		27
35	Ашиглалтын инженер буюу хэсгийн дарга	1
36	Механикч	1
37	Бактерлогич	1
38	Дулааны шугам хоолойн слесарь	10
39	Бохир усны слесарь	4
40	Гагнуурчин	3
41	Био шүүлтүүр, лаг талбай, хлорт байгууламжийн операторч	4
42	Гүний худгийн харуул	1
43	Ус түгээгч	1
44	Усны машины жолооч	1
Нийт		101



ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын жагсаалт батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалт, Эрчим хүчний сайдын 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн а/2969 дугаар удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Дулаан шарын гол" ТӨХК-ийн Авлигатай тэмцэх газраар хувийн ашиг сонирхолын мэдүүлгийг хянуулах Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн томилогддог албан тушаалтнууд болон компанийн нэгжийн удирдлага /салбар, хэлтэс, алба, цех/ түүнээс дээших албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэх захирал /П.Баярцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ГАНЗОРИГ



**“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн Шинээр томилогдсон
болон, сонгогдсон хөрөнгө, орлогын мэдүүлэг
гаргах албан тушаалтнуудын жагсаалт**

- Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд
- Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга
- Дотоод аудитор
- Ерөнхий инженер
- Ерөнхий нягтлан бодогч
- Захиргаа удирдлагын хэлтсийн дарга
- Техникийн хэлтсийн дарга буюу горим тооцооны инженер
- Дулааны станц хэсгийн дарга буюу ашиглалтын инженер
- Ус дулаан ариутгах татуургын хэсгийн дарга буюу ашиглалтын инженер



ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

“Дулаан шарын гол” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Компанийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшний биелэлт, аудитаас өгсөн зөвлөмжийн биелэлтийн тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

...”2023 оны эхний хагас жилийн төлөвлөгөөгөөр 21.6 мянган гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэхээс 21.9 мянган гкал дулаан үйлдвэрлэж 101.3 хувь, 152.3 мянган м³ ус олборлох төлөвлөгөөтэйгөөс 136.9 мянган м³ ус олборлон 89.9 хувь, 133.6 мянган м³ бохир ус татан зайлуулах төлөвлөгөөтэйгөөс 120.7 мянган м³ бохир ус татан зайлуулж 90.3 хувийн тус тус биелэлттэй байна. ...гэж тэмдэглэв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Компанийн 2023 оны техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний батлагдсан төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр хангаж ажиллахыг гүйцэтгэх захирал /П.Баярцэцэг/-д үүрэг болгосугай.

2. Өр төлбөрийн дүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурч байгаа боловч хуримтлагдсан их өр төлбөр нь санхүүгийн хувьд хүндрэлд оруулах эрсдэлтэй тул нэмэгдүүлэхгүй байх, ажлын төлөвлөгөө гаргаж биелэлтийг ханган ажиллах, өр төлбөрийг хугацаанд нь барагдуулах тал дээр онцгой анхаарч ажиллахыг гүйцэтгэх удирдлагуудад үүрэг болгосугай”...гэжээ.

ДАРГА



Ш.ГАНЗОРИГ



**ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 09 сарын 14 өдөр

Дугаар **03**

Улаанбаатар хот

“Дулаан шарын гол” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Компанийн 2023 оны эхний хагас жилийн үндсэн ба эргэлтийн хөрөнгийн тооллогын дүнгийн тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

....”2023 оны эхний хагас жилийн үндсэн ба эргэлтийн хөрөнгийн тооллогыг гүйцэтгэх захирлын 2023 оны А/14 дүгээр тушаалаар томилогдсон тооллогын комисс хийж гүйцэтгэсэн. Тооллогоор 359 нэр төрлийн 8,473.8 сая төгрөгийн балансын үнэтэй үндсэн хөрөнгө тоологдсон. Агуулахын бараа материалыг нэг бүрчлэн тоолоход 107.6 сая төгрөг бүхий 14 дансны 459 ширхэг бараа материал тоологдсон. Эд хариуцагчийн тооцоо бодож дансны бүртгэлтэй тулгаж үзэхэд бараа материал дутсан болон бусад зөрчил гараагүй... гэж тэмдэглэв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1.Компанийн 2023 оны эхний хагас жилийн үндсэн ба эргэлтийн хөрөнгийн тооллогын дүн “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2.Үндсэн ба эргэлтийн хөрөнгийн тооллогын акт, бусад баримт материалыг холбогдох хууль, журмын дагуу бүрдүүлэн ажиллахыг гүйцэтгэх захирал /П.Баярцэцэг/-д үүрэг болгосугай...гэжээ.

ДАРГА



Ш.ГАНЗОРИГ



**ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

“Дулаан шарын гол” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

...”Өвөлжилтийн бэлтгэл хангах их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр 219.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 багц ажил төлөвлөж нийт ажлын гүйцэтгэл 95.7 хувьтай, зуух, туслах тоноглол, шугам сүлжээний урсгал засвараар 75.1 сая төгрөгийн төсөвт өртгөөр 20 багц ажил төлөвлөж нийт ажлын гүйцэтгэл 98.5 хувьтай байна....гэж тэмдэглэв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1.Компанийн техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалт, их засварын төлөвлөгөөнд тусгасан ажлыг 2023 оны 10 дугаар сарын 15-ны дотор чанартай хийж дуусгахыг гүйцэтгэх захирал /П.Баярцэцэг/, ерөнхий инженер /Л.Нарангэрэл/ нарт үүрэг болгосугай...гэжээ.

ДАРГА



Ш.ГАНЗОРИГ